

МОНГОЛ, ДАНИЙН ХАРИЛЦАА: ХОЁР ОРНЫ ХООРОНД ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТОЖ ХӨГЖСӨН НЬ

Б.Санжмятав¹

Нэг. Монгол, Данийн харилцааны суурь тавигдсан нь

Данийн судлаачид 1920-1930 онд Монголд ирж, эрдэм шинжилгээний ажлаа явуулан Хөвсгөлд амьдарч байсан² нь бидэнд мэдэгдэж байгаа баримт юм. Ийнхүү Монголд амьдарч байсан хүмүүсийн дотор одоогийн Данийн хатан хааны ордны маршал С.Хаслунд-Кристенсены өвөг эцэг нь байсан нь эдүүгээ ч хоёр орны харилцааны гүүр болсоор байгаа нь бахархуштай түүх болно.

Улс орнуудын хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хувь хүмүүс чухал үүрэг гүйцэтгэдэг, зарим тохиолдолд хувь хүмүүсийн харилцаагаар дамжин улс хоорондын харилцаа хөгждөг уламжлал олон улсын харилцаанд байдаг билээ. Энэчлэн Монгол, Данийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд маршал С.Хаслунд-Кристенсен, зохиолч, сэтгүүлч Иорген Бич гэдэг хоёр хүн чухал үүрэг гүйцэтгэж ирсэн байна.

Маршал С.Хаслунд-Кристенсен өвөг эцгийнхээ түүхийг сонирхон 1986, 1990 онд Монголд Данийн киноны хэсгийнхэнтэй ирж, Хөвсгөл аймгийн Эгүүрийн САА-тай танилцан зураг авч байжээ. С.Хаслунд-Кристенсен Монголтой тогтоосон холбоогоо гүнзгийрүүлэн 1995 онд Монголд айлчлахдаа манай төр, засгийн удирдлагууд, олон нийтийн байгууллагуудын төлөөлөгчидтэй уулзаж, хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал солилцож байсан байна.

Ирген Бич Монголын түүх, соёлыг сонирхон судлаж, Монголын талаар олон нийтэд таниулах ажлыг эхлүүлсэн гавьяатай хүн болно. Тэрээр Монголд ирж зураг авч кино хийх, ингэхдээ эхлээд Дани, Скандинавын орнуудын сургуулийн хүүхдүүдэд танилцуулах санаачилгыг 1957 оноос гаргаж, Монголын Москва дахь ЭСЯ-аар дамжуулан хөөцөлдсөөр манай визийг авчээ. Тэрээр 1958 оны зуны наадмаар Монголд зочилж, зураг авсан ба Монголын талаар өнгөт кино бүтээж, бичиж авсан дуу, хөгжмөө пьанзанд бичиж, 8 өгүүлийг Данийн болон Скандинавын орнуудын хэвлэлд нийтлүүлсэн³ ажээ. Мөн Копенгагений Их сургуулийн Төв Азийн институтын судлаач Жон Лаурберг Монголын уйгаржин болон

¹ МУИС-ийн ОУХ-ийн багш, доктор (Ph.D)

² ГХЯ-ны дэргэдэх Гадаад харилцааны төв Архив, ф 42, данс 1, хн-34, х 102

³ ГХЯ-ны дэргэдэх Гадаад харилцааны төв Архив, ф 42, хн-3, х 142

крилл үсгийг сонирхон судлаж, 1958 онд Монголд ирж байжээ.

Иорген Бич 1961 онд Монголд дахин ирж ажиллах үеэрээ түүнийг дагалдан үйлчилж байсан дипломатад дараах зүйлийг ярьж байсныг нь архивт бичиж үлдээжээ. Тухайлбал Монголын хувьсгалаас өмнө Данийн олон эрдэмтэд, гол төлөөлөгчид нь Томсен, Хеннинг, Хаслунд Кирстенсен, Свен Хедин нар Монголд удаан хугацаагаар сууж, эрдэм шинжилгээний ажил хийж байсан ба тэд 40 орчим боть номыг бичиж үлдээжээ. Эдгээр номонд Монголын талаар нааштайгаар бичсэн байдаг. Мөн Данийн зарим иргэн Монголд газар тариалан эрхэлж байсан. Тухайлбал Иорген Бичийн таних Карл Кребс гэр бүлийн хамт анх 1918-1919 оны үед Хятадаас тэмээгээр Монголд нүүж ирээд, Хөвсгөл аймагт газар тариалан эрхэлж байгаад 1930-аад онд зарим хөрөнгөө Монголын Засгийн газарт хураалгаад нутаг буцсан, одоо 65 настай амьд сэрүүн байгаа гэж ярьжээ. Ийнхүү Данид Монголын талаар эртнээс сонирхон судлаж, ном хэвлэж байсан тул Иорген Бич ч дээрх урсгалд хамрагдсан хүмүүсийн нэг гэдгээ хэлж байжээ.

Тухайн үед Иорген Бичийн зүгээс Монголын талаар кино хийж, зураг, өгүүлэл хэвлэлд нийтлүүлэх гэж байгаа нь хоёр орны харилцааг ойртуулахад дөхөм болно гэдэгт хатуу итгэж байна. Учир нь Данийн засгийн газар Монгол орныг сонирхож, мэдээлэл олж авах хүсэлтэй байгаа. Түүний илрэл нь Данийн Гадаад яам түүнийг Монголд явж ажиллахыг дэмжиж, албан паспорт олгосон явдал болно гэж хэлж байжээ⁴.

Иорген Бич хэсэг нөхдийн хамт 1982 онд Монгол, Данийн найрамдлын нийгэмлэгийг санаачлан байгуулсан боловч төдийлөн идэвхтэй үйл ажиллагаа явуулж амжаагүй байна. Тэгээд 1990 онд найрамдлын нийгэмлэгийн үйл ажиллагааг дахин сэргээснээс хойш идэвхтэй ажиллах болжээ. Маршал С.Хаслунд-Кристенсен Монгол, Данийн найрамдлын нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцон, ялангуяа улс төрийн хэмжээнд томоохон дэмжлэг үзүүлж ажилладаг байна.

Хоёр. Монгол, Данийн хооронд дипломат харилцаа тогтоох үеийн олон улсын байдал, онцлог

Монгол, Данийн хооронд дипломат харилцааг албан ёсоор 1968 оны 8 дугаар сарын 5-нд тогтоосон. Гэхдээ дипломат харилцаа тогтоох хоёр талын яриа хэлэлцээ, үйл явц нэлээд удаан хугацаанд үргэлжлэн явагдаж, урагшилсаар дээр дурдсан өдөр дипломат харилцаа тогтоосон байдаг.

1950-иад оноос Данид Монгол улсыг сонирхон янз бүрийн шугамаар мэдээлэл цуглуулж, Москвад элчин сайд нар уулзахдаа энэ чиглэлээр байнга ярилцаж байсан байна. 1947 оноос хоёр орны элчин сайд нар Москвад ИЖБ барьсан тухайгаа харилцан мэдээлж, харилцан танилцах уулзалт хийж байсан тухай баримтууд Монголын Гадаад харилцааны яамны төв архивт байна. Монголын Засгийн газар 1950-иад онд Дипломат харилцаа тогтоож болох найрсаг орны жагсаалт батлаж байсан бөгөөд тэдгээр орны тоонд Дани орж байжээ⁵.

⁴ Данийн зохиолч, кино зурагчин Иорген Бичийг Монголд хүлээн авч үйлчилсэн тухай илтгэх хуудас, ГХЯ-ны дэргэдэх Гадаад харилцааны төв Архив, ф 42, хн-2

⁵ ГХЯ-ны дэргэдэх Гадаад харилцааны төв Архив, ф 42, хн-4

Монгол улсын Засгийн газар НҮБ-д элсэх чиглэлээрх үйл ажиллагааныхаа хүрээнд 1955 оны намар Данийн Засгийн газрын дэмжлэг хүсч ноот илгээж байсан байна. Данийн тал Монголын энэхүү хүсэлтэд хүндэтгэлтэйгээр хандан, асуудлыг боловсруулах ажлынхаа хүрээнд Москва дахь манай ЭСЯ-наас мэдээлэл, ном, материал цуглуулан авч байсан баримт үлдсэн ажээ. 1957 онд Монголын Элчин сайд Б.Очирбат 1957 оны 3 дугаар сарын 1-нд Данийн элчин сайдын хүлээн авалтад очих үеэр Данийн Элчин сайдаас Скандинавын 4 орон саяхан хуралдаад Монголыг НҮБ-д элсэх асуудлыг дэмжих шийдвэр гаргаснаа мэдэгдэж байсан байна⁶. Энэхүү шийдвэр нь Монгол улсыг тэдгээр орны зүгээс албан ёсоор буюу деюре хүлээн зөвшөөрсөн хэрэг болох бөгөөд олон улсын дипломат практикт дипломат харилцаа тогтоохын өмнөх шат болдог.

Одоо Монгол, Данийн хооронд дипломат харилцаа тогтоохын өмнө олон улсын улс төрийн нөхцөл, байдал ямар байсныг авч үзье.

БНМАУ-ын олон улсын нэр, нөлөө улам бүр бэхжиж, дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хүрч байсан болно.

Монгол улс дэлхийн хоёрдугаар дайнд ЗХУ-ын холбоотон нь байж, өөрт байгаа бүхий л бололцоотой тусламжийг үзүүлж байсан тул ЗХУ Алс Дорнодод Японы эсрэг дайнд орохын тулд Монголын статус кво буюу Монголын тухайн үеийн тусгаар байдлыг хүлээн зөвшөөрүүлэх нөхцлийг тавьж, холбоотон гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлсэн юм. Энэ үндсэн дээр Монголын арми ЗХУ-ын цэргийн хамтаар Японы эсрэг дайнд оролцож, Хятадыг чөлөөлөхөд өөрийн хувь нэмрээ оруулсан юм. Түүний дараагаар Хятадын Засгийн газрын хүсэлтээр Монголд тусгаар тогтнолын асуудлаар бүх нийтийн санал хураалт зохион байгуулж, ард түмэн 100%-ийн санал өгсөн нь Монгол улсын тусгаар тогтнолыг дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн болно. Хятадын Засгийн газар Монголд явуулсан бүх нийтийн санал хураалтын дүнг хүлээн зөвшөөрч, Монгол улсын Засгийн газраас НҮБ-д элсэх хүсэлтээ 1946 онд гаргахад түүнийг дэмжиж үг хэлсэн байдаг.

1950-1960-аад онд Дэлхийн социалист систем бүрэлдэн тогтож, олон улсын харилцааны тогтолцоонд нөлөө бүхий хүч болсон ба Ази, Африк, Латин Америкийн олон орон колоничлолын системийг түлхэн унагааж, тусгаар тогтнолоо зарлаж, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн байгуулагдан хүчээ авч, шинээр тусгаар тогтносон орнууд НҮБ буюу дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн болж байсан үе билээ. 1945 онд НҮБ-ыг үүсэн байгуулагдахад гишүүдийн тоо 45 байсан бол, 1960 онд 99 болж өссөн байдаг. Ийнхүү олон улсын харилцааны цоо шинэ тогтолцоо бүрэлдэн бий болж байсан юм. Энэ нөхцөлд БНМАУ дэлхийн социалист системийн бүрэлдэхүүн хэсэг болж, шинээр тусгаар тогтносон орнуудтай идэвхтэй бөгөөд ойр хамтран ажиллаж байсан. Тухайлбал 1960 он гэхэд БНМАУ дэлхийн 16 оронтой дипломат харилцаа тогтоож, тэдгээрийн хагас нь колонийн системээс чөлөөлөгдөж, тусгаар тогтносон орнууд байлаа.

Монголын Засгийн газар НҮБ-д элсэх чиглэлээр идэвхтэй ажиллаж, байсны дүнд НҮБ-д 1961 онд элсэж, дэлхийн хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүн болсон юм. Гэхдээ Монгол улсыг НҮБ-д элсэхэд хөгжиж буй орнуудын бүлэг чухал үүрэг гүйцэтгэсэн болохыг онцлон тэмдэглэх хэрэгтэй юм. Учир нь тухайн үед социалист орнууд НҮБ-д

⁶ ГХЯ-ны дэргэдэх Гадаад харилцааны төв Архив, ф 42, хн-3

Монгол улсыг түрүүлж элсүүлэх бодлогыг баримталж, гишүүн элсүүлэх ажиллагааг саатуулаад байхад, хөгжиж буй орнууд Мавританийг элсүүлэхийн төлөө ажиллаж байсан. Хөгжиж буй орнууд Монголыг НҮБ-д элсэхэд гол саад болж байсан Чан Кай Ши-гийн Хятадад даралт үзүүлэх замаар түүнийг санал хураалтад оролцохгүй болгож, хоёр орныг зэрэг элсүүлэх бололцоог нээж өгсөн юм. Монголыг НҮБ-д элссэний дараа дипломат харилцаатай орны тоо эрс нэмэгдэж, 1968 оны байдлаар 40 болж нэмэгдсэн байна. Ийнхүү Монгол улс НҮБ-д элссэн нь манай орны олон улсын нэр хүндийг ихээхэн өргөж, дэлхийн хамтын нийгэмлэгийн бүрэн хэмжээний оролцогч болоход чухал үүрэг гүйцэтгэжээ.

Монгол улс Европын орнуудаас анх түрүүн 1963 онд Их Британи, Австри, Финляндтай, дараа нь 1964 онд Швейцарь, Шведтэй, 1965 онд Францтай, 1967 онд Гректэй, 1968 онд Норвеги, Данитай тус тус дипломат харилцаа тогтоожээ.

Дани тухайн үед гадаад бодлогодоо прагматик бодлого баримталж, аливаа улс оронтой дипломат харилцаа тогтоохын өмнө худалдааг хөгжүүлэхийг зорьж байсан болох нь архивын баримтаар нотлогддог. Тухайлбал 1963 оны 10 дугаар сарын 11-нд Данийн Элчин сайд Москвад Монголын Элчин сайдтай уулзахдаа “Данийн тал хоёр орны хооронд худалдаа хөгжихгүй байгаа тул дипломат харилцаа тогтооход яарахгүй байгаа” талаар мэдээлжээ. Ингээд Монголын Москва дахь ЭСЯ-наас Данитай худалдааг хөгжүүлэх бололцоо, тээврийн тариф, шаардлагын талаар судалгаа хийж ГЯЯ-ндаа ирүүлж байсан байна⁷. Данийн тал ч Монголтой худалдааг хөгжүүлэх бололцооны талаар судалгаа хийж, манай ЭСЯ Данийн талд холбогдох мэдээллийг хүргүүлж байсан баримтууд архивт байгаа.

Данийн ЗХУ-д сууж байсан Элчин сайд Анвер Сварт манай элчин сайд Н.Лувсанчүлтэмтэй 1968 оны 7 дугаар сарын 15-ны өдөр ирж уулзахдаа “Данийн Засгийн газар БНМАУ-тай дипломат харилцааг тогтооход бэлэн байгаа, мөн Элчин сайд Анвер Свартыг Монголд Москвагаас хавсарган томилох хүсэлтэй байгаа” тухай албан ёсоор мэдэгдэж, албан ёсны ноот гардуулжээ. Монголын Элчин сайд Н.Лувсанчүлтэм Данийн Элчин сайдад талархал илэрхийлэхийн ялдамд, “Монгол улс Скандинавын орнууд, түүний дотор Данитай төв түвшин харилцаатай явж ирсэн, энэ удаа хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох асуудлыг Монголын тал нааштайгаар хүлээн авна гэж бодож байгаа”-гаа хэлжээ. Ийнхүү хоёр орны хооронд албан ёсоор дипломат харилцаа тогтоох тухай мэдэгдлийг Москвагаар Элчин сайд нарын түвшинд тохиролцож, 1968 оны 8 дугаар сарын 5-нд хоёр талдаа нэгэн зэрэг зарласан байна. Ийнхүү Данийн Вант улс Монгол улсын дипломат харилцаатай 40 дэх орон болсон түүхтэй байна.

Гурав. Монгол, Данийн харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал

Одоо Дани улс Монголын хамгийн найрсаг харилцаатай, Европын түнш, ЕХ-ны тусламжийг Монголд хэрэгжүүлэгч нэг гол орон болсон байна.

1990-ээд оноос хойшхи хугацаанд Данийн талаас Монголд Гадаад хэргийн сайд 1996 онд, угсаа залгамжлагч хан хүү Монголд 2008 онд, Монголын талаас Данид Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2010 онд, УИХ-ын дарга Н.Багабанди 1994 онд, Ц.Нямдорж 2006 онд, Гадаад хэргийн сайд Ш.Алтангэрэл 1998 онд, Н.Энхболд 2007 онд тус тус айлчилсан.

⁷ ГХЯ-ны дэргэдэх Гадаад харилцааны төв Архив, ф 42, хн-4, Уулзалтын тэмдэглэл 82

Монгол, Данийн хооронд 1995 онд хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр байгуулагдсан.

Данийн анхны Элчин сайд Анвер Сварт 1968 онд БНМАУ-ын төрийн тэргүүнд, Монголын Элчин сайд С.Дамбадаржаа 1969 онд Данийн Хатан хаанд тус тус ИЖБ-ээ тус тус барьжээ. Одоо Монголын Стокгольм дахь ЭСЯ Данийг, Данийн Бээжин дэх ЭСЯ Монголыг тус тус хавсран ажиллаж байна. Монгол улс өөрийн өргөмжит Консулыг Данид 1995 оноос томилон ажиллуулж байна. Одоо өргөмжит консулаар С.Хаслунд-Кристенсен ажиллаж байна.

Данийн Засгийн газар Монголыг шилжилтийн орнуудын тусламжийн хөтөлбөртөө хамруулан нийт 30 орчим сая ам. долларын буцалтгүй тусламжийг мал аж ахуй, эрүүл мэнд, эрчим хүч, боловсрол, ардчиллыг дэмжих чиглэлээр олгож, нийтдээ 40 гаруй төслийг хэрэгжүүлжээ. Данийн талаас Монголд тусламж үзүүлж байсан “Шилжилтийн үеийн хөтөлбөр”-өө 1998 онд зогсоож, харин төрийн бус байгууллагуудын шугамаар төслүүд хэрэгжүүлж эхэлсэн. Тэдгээрийн дотор томоохон нь Дани, Монголын сургалтын төв, хөдөөгийн сургалтыг хөгжүүлэх төсөл, Хэвлэл, мэдээллийн мониторингийн төслүүд болно.

Монгол, Данийн худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа төдийлэн хөгжиж чадаагүй байна.

Хоёр орны худалдаа 2002 оноос эрс буурсан байна. Монгол Даниас эм, эмийн бүтээгдэхүүн, өргөгч, ачигч машин, тоног төхөөрөмж, эд анги зэргийг импортолж, оёмол, сүлжмэлийн бүтээгдэхүүнийг экспортолж байгаа ажээ.

Хөрөнгө оруулалтын салбарт одоогийн байдлаар Данийн нэг компани 230 мянган ам. долларын хөрөнгө оруулалтыг хийж, боловсрол, худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ажээ.

Монгол улсын эдийн засаг сүүлийн 10 жилд дунджаар 9%-иар өсч, цаашдаа 2 оронтой тоо бүхий хувиар өсөх төлөвтэй тул гадаадын хөрөнгө оруулалт ихээр ирж байгаа болно. Энэ нөхцөлд Европын, түүний дотор Данийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх өргөн бололцоо байна. Тухайлбал ХАА, МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах, ногоон эдийн засгийг хөгжүүлэх, хөнгөн үйлдвэр, мэдээллийн технологи, үйлчилгээг хөгжүүлэх зэрэг салбарт хамтран ажиллах бололцоотой болно. Энэ үүднээс хоёр орны бизнесийн хүмүүсийн хооронд холбоо тогтоох, ажил хэрэгч уулзалт зохион байгуулах шаардлагатай байна гэж үзэж байна.

Монгол, Данийн хоорондын харилцаа, хамтын ажиллагааны тодорхой асуудлуудыг бусад илтгэгчид ярих тул үүгээр өөрийн илтгэлээ дуусгая.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Дипломат харилцаатай орнууд

Хавсралт 1

1.	ОХУ - Оросын Холбооны Улс	1921.11.05
2.	Солонгос (Хойд) - Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс	1948.10.15
3.	Албани - Бүгд Найрамдах Албани Улс	1949.05.24
4.	Хятад - Бүгд Найрамдах Хятад Ард Улс	1949.10.16
5.	Польш - Бүгд Найрамдах Польш Улс	1950.04.14
6.	Болгар - Бүгд Найрамдах Болгар Улс	1950.04.22
7.	Унгар - Бүгд Найрамдах Унгар Улс	1950.04.28
8.	Румын - Румын Улс	1950.04.29
9.	Вьетнам - Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс	1954.11.17
10.	Энэтхэг - Бүгд Найрамдах Энэтхэг Улс	1955.12.24
11.	Мьянмар - Мьянмариин Холбооны Улс	1956.09.26
12.	Серби, Мотенегро - Серби, Мотенегро Улс	1956.11.20
13.	Индонези - Бүгд Найрамдах Индонези Улс	1956.12.22
14.	Гвиней - Бүгд Найрамдах Гвиней Улс	1960.04.22
15.	Камбож - Камбожийн Вант Улс	1960.11.30
16.	Куба - Бүгд Найрамдах Куба Улс	1960.12.07
17.	Балба - Балбын Вант Улс	1961.01.05
18.	Мали - Бүгд Найрамдах Мали Улс	1961.01.25
19.	Алжир - Бүгд Найрамдах Ардчилсан Алжир Ард Улс	1961.06.25
20.	Афганистан - Лалын Шилжилтийн Афганистан Улс	1962.02.01
21.	Шри Ланк - Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланк Улс	1962.02.01
22.	Ирак - Бүгд Найрамдах Ирак Улс	1962.02.05
23.	Пакистан - Лалын Бүгд Найрамдах Пакистан Улс	1962.07.06
24.	Лаос - Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс	1962.09.12
25.	Их Британи (Англи) - Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	1963.01.23
26.	Египет - Арабын Бүгд Найрамдах Египет Улс	1963.04.02
27.	Австри - Бүгд Найрамдах Австри Улс	1963.07.01
28.	Финланд - Бүгд Найрамдах Финланд Улс	1963.07.15
29.	Швейцар - Швейцарын Холбооны Улс	1964.05.22
30.	Швед - Шведийн Вант Улс	1964.06.30
31.	Франц - Бүгд Найрамдах Франц Улс	1965.04.27
32.	Гана - Бүгд Найрамдах Гана Улс	1965.12.07
33.	Конго - Бүгд Найрамдах Конго Улс	1966.12.31
34.	Танзани - Бүгд Найрамдах Нэгдсэн Танзани Улс	1967.01.17
35.	Этиоп - Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп Улс	1967.01.24
36.	Грек - Бүгд Найрамдах Грек Улс	1967.03.03
37.	Мавритани - Лалын Бүгд Найрамдах Мавритани Улс	1967.06.30
38.	Сири - Арабын Бүгд Найрамдах Сири Улс	1967.07.31
39.	Норвег - Норвегийн Вант Улс	1968.01.11
40.	Дани - Данийн Вант Улс	1968.08.05